



Завхан голын ай савыг жимсний цэцэрлэг байгуулж хамгаалах арга барил

Завхан аймаг, Дөрвөлжин сум, Завхан гол

Дөрвөлжин сум нь уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн улиралд дундажаар 35-40 хэм хүйтэн, зуны улиралд дундажаар 30-35 хэм дулаан, ихэвчлэн хуурай уур амьсгалтай, жилд унах хур тунадасны хэмжээ дундажаар 38,1 мм. Элсэнцэр, элсэрхэг цайвар хүрэн, говийн хужирлаг, мараалаг бор хөрс бүхий цав толгод зонхилсон гадаргатай. Дөрвөлжин сумын захаар Завхан гол урсан Их Монгол элсийг эмжин 808 км урсахдаа баруун дөрвөн нутгаар дайран өнгөрдөг. Завхан гол нь Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэрийн өврөөс эх авах Буянт гол, Шар усны голын бэлчрээс эхлэн Завхан гол хэмээн нэрлэгдэнэ. Голын урсгал Тайширын усан цахилгаан станцыг барьснаас хойш ихээхэн татарч байгаа бөгөөд голдирол элсэнд дарагдах аюул нүүрлээд байгаа юм. Тиймээс Завхан голын ай савыг хамгаалах нөхөн сэргээх ажлыг үр шимийг хүртэгч хүн бүхэн хичээл зүтгэл гаргавал тодорхой үр дүнд хүрэх юм. Завхан голын ай савыг хамгаалах ажлын хүрээнд Дөрвөлжин сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулж 2009 онд 1 га талбайг хашиж хамгаалан 900 ш чацарганы бут суулгаж, модны тогоог нь нийллэг хальсаар бүрсэн нь үр дүн сайтай болжээ. Энэхүү ажлыг цаашид өргөжүүлж орон нутагт ургадаг чацарганыг үржүүлэн, нөхөн сэргээлтэд ашиглах зорилго тавин ажиллаж байна. Хашиж хамгаалан чацарганы төгөл байгуулсан талбайн бэлчээрийн ургамал сэргэн мэдэгдэхүйц сайжирсан нь элсийг тогтоон барьж, хөрсийг бэхжүүлэх эерэг нөлөөтэй байна.

Зүүн зургийн тайлбар: Чацарганы төгөл, ургамал сэргэн ургасан байдал

Баруун зургийн тайлбар: Завхан голын өнөөгийн төрх бйдал



Байршил: Завхан аймаг, Дөрвөлжин сум

Газар ашиглалтын төрөл: Бэлчээрийн газар

Уур амьсгал: Хуурай

MONCAT мэдээллийн сангийн нэр зүй: QA MON-17.

Холбогдох технологи: QA MON - 1

Арга барилыг нэвтрүүлсэн хүн/байгууллага: Галрагчаа, Завхан аймгийн БОАЖ-ын газар, Дөрвөлжин сумын Засаг даргын тамгын газар, "Ээлтэй нутаг" хоршоо

Холбогдох утас: 88072107, 0146462107.

Мэдээллийг цуглуулсан хүн/байгууллага: А.Хауленбек, Л.Мөнхнасан, Ц.Ганчөдөр - Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв.

Он, сар, өдөр: 2009 оны 10-р сарын 14

Эмхэтгэгчийн тайлбар: Тухайн арга барил нь голын ай савыг ойжуулж, усыг зохистой ашиглах замаар экологийн нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн байна.

Асуудал, зорилго, бэрхшээл**Тулгарч буй асуудал**

1. Завхан голын урсгал татарч байгаа
2. Мэдлэг, менежмент сул
3. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хур тунадас багассан
4. Голын ай савыг нөхөн сэргээх арга хэмжээ зайлшгүй шаардлагатай байгаа

Зорилго

Завхан голын ай савыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг байгаль экологид ээлтэй, орон нутгийн ард иргэдэд ашигтай замаар нийтийн үйл хэрэг болгох.

Шийдвэрлэхэд чиглэгдсэн асуудал

Үндсэн	Товч тодорхойлолт	Шийдвэрлэх арга зам
Голын ай савыг хамгаалах	Завхан голын урсгал татарч байна	Голын ай савыг зөв зохистойгоор ашиглах арга замыг эрэлхийлэх
Нөхөн сэргээх	Хашиж хамгаалах, мод, сөөг ургамал тарих	Чацарганы төгөл байгуулах
Ард иргэдийн оролцоог дэмжих	Нөхөрлөл байгуулах, чацарганы бут тарих	Бэлчээрийг нөхөрлөлийн журмаар эзэмшүүлж, нөхөн сэргээх, сайжруулах арга хэмжээг орон нутгийн удирдлагын зүгээс дэмжиж өгөх
Мэдлэг, менежмент	Мэдлэгийг олгож, иргэдийн байгаль орчноо хамгаалах үйлсийг дэмжиж, урамшуулах	Сургалт, сурталчилгаа явуулах, мэдээлэлийг түгээх замаар олон нийтэд үр өгөөжийг нь таниулах

Оролцоо, шийдвэр гаргах**Нийгмийн бүлэг**

Ажилчин газар ашиглагчид



Орон нутгийн удирдлага



Байгаль орчны алба


Арга барилд шаардагдах зардал

“Канадын сан” олон улсын байгууллага	50%
“Ээлтэй нутаг” хоршоо	50%
Нийт	100%

Технологи сонголтод шийдвэр гаргагчид: Орон нутгийн ЗДТГ, БОАЖГ, иргэд, нөхөрлөлүүд
Арга барилыг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргагчид: БОАЖЯ, орон нутгийн БОАЖГ, сумын ЗДТГ
Оролцооны зарчмын бүрдүүлэгч: Иргэд

Нийгмийн оролцоо

Үе шат	Оролцоо	Үйл ажиллагаа
Эхлүүлэх	Судлаачид, мэргэжлийн байгууллагууд	Судалгаа шинжилгээний үндэстэйгээр нөхөн сэргээх, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөнө.
Төлөвлөх	БОАЖЯ, орон нутгийн БОАЖГ газар, ЗДТГ-ын захиргаа	Чиг үүрэг өгч, шаардлагатай бол төсөв санхүүг шийдэж өгнө
Хэрэгжүүлэх	Орон нутгийн БОАЖГ, ЗДТГ, төсөл хөтөлбөр, сумын иргэд	Удирдан чиглүүлж, санхүүгийн эх үүсвэрээр дэмжиж өгсөн
Мониторинг/үнэлгээ хийх	Мэргэжлийн байгууллага судлаачдыг ажиллуулдаг	Тухай бүр БОАЖЯ-нд тайлан мэдээг гаргаж өгдөг
Судалгаа	Тодорхой бус	Тодорхой бус



Мэдлэг түгээн дэлгэрүүлэх

Сургалт: Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг, “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-ийн шугамаар 2 удаа иргэд, нөхөрлөлүүдэд тус талбайг түшиглэн мод, сөөг тарьж ургуулах талаар сургалт явуулсан.

Түгээн дэлгэрүүлэлт: “Ээлтэй нутаг” хоршоо Дөрвөлжин сумын “Хар бут” хэмээх нутагт ургах чацарганы төгөлийг хамгаалах, сийрэгжүүлэх, нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн байна.

Судалгаа: Тодорхой бус.

Орон нутгийн дэмжлэг: Орон нутгийн Засаг даргын тамгын газрын зүгээс дэмжин ажиллаж 8 нөхөрлөл байгуулан “Хар бут”-ны чацарганы төгөлийг сумын нутгийн иргэдэд эзэмшүүлж өгсөн байна. “Ээлтэй нутаг” хоршоо тус төгөлөөс 300 га талбай эзэмшихийн зэрэгцээ Завхан голын ай сав дагуу 5 га газарт чацарганы төгөл байгуулан ажиллаж байна.

Урамшуулал

Ажиллах хүч: Хоршооны гишүүн 19 хүн.

Хөрөнгө оруулалт: “Ээлтэй нутаг” хоршоо, “Канадын сан” олон улсын байгууллага.

Зээл олголт: “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас эргэн төлөгдөх зээл авсан.

Орон нутгийн байгууллагуудад үзүүлэх дэмжлэг: Дөрвөлжин сумын төвд хэд хэдэн газар улиас, сургуульд 200 ширхэг бургас тарьж өгсөн. Мөн Завханмандал сумд 14 га газарт улиас, бургас, чацарганы 5000 ширхэг суулгац тарьж ургуулах ажлыг гүйцэтгэсэн.

Урамшуулал олгохын урт хугацааны нөлөө: Эерэг нөлөөтэй

Мониторинг үнэлгээ

Мониторингийн объект	Индикатор	Газар ашиглагчдын санаачлага
Био-физик	Голын ус	Голын ай савыг хамгаалах замаар усны урсацыг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах.
Техник	Чацарганы бут тарих, хашиж хамгаалах	Байгаль экологид ээлтэй газар ашиглалтын хэлбэрийг сонгох
Эдийн засгийн үр ашиг	Ашиг орлого	Жимс жимсгэнээ зах зээлд нийлүүлэх, хадлан бэлтгэх зэргээр ашиг шимийг нь хүртэнэ.
Хамрах талбай	Завхан голын ай сав дагуух бэлчээр нутаг	Нөхөрлөлийн журмаар голын ай сав дагуух газрыг эзэмших, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг нэмэгдүүлэх.

Арга барилын үзүүлэх үр нөлөө

Мониторинг, үнэлгээ хийсний үндсэн дээр гарсан өөрчлөлтүүд: Мониторинг, үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд үр дүн нь тодорхой бус

Хөрс, усны менежмент сайжрах: Уг арга барилыг хэрэгжүүлснээр Завхан голын ай сав дагуу газруудыг ашиглах менежмент сайжирна.

Бусад төсөл, газар ашиглагч нар арга барилд суралцаж эзэмшсэн эсэх: Дөрвөлжин сумын нутаг дахь “Хар бут”-ны төгөлийг анх удаа сэргээх, хамгаалах ажлыг өрнүүлж нөхөрлөл байгуулах суурийг тавьсан бөгөөд одоогоор 8 нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна.

Тогтвортой байдал: Тогтвортой үр ашгийг нь хүртэх боломжтой

Дүгнэлт

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах	Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах
→ Орон нутгийн удирдлагын зүгээс мод тарих бүхийл арга хэлбэрийг дэмжиж ажилладаг.	→ Урамшуулал олгох, төсөл хөтөлбөрт хамруулах, мэдлэгийг түгээхэд анхаарч ажиллах.
→ Байгаль экологид сөрөг нөлөөгүй арга замыг сонгосон.	→ Мэргэжлийн зүгээс гарын авлага материалаар хангаж өгөх, сургалтанд хамруулах.
→ Орон нутагт ургадаг чацарганы бутыг үржүүлэн нөхөн сэргээлтэнд ашиглах боломжтой.	→
→ Ус, газар ашиглах эрх нээлттэй.	→

Дөрвөлжин сумын төвөөс баруун тийш 30 км-ийн зайд “Хар бут” хэмээх зэрлэг чацарганы төгөл орших бөгөөд Завхан голын хөвөөнөө уртаашаа 30 орчим км талбайд тархан ургадаг. Ойр орчмын аймаг, сумдаас чацаргана түүхээр ирсэн иргэд доргиох, хугалах зэргээр төгөлийг сүйтгэдэг байжээ. Дөрвөлжин сумын Засаг даргын тамгын газраас сумын нийт айл өрхүүдийг найман нөхөрлөл болгон, чацарганы төгөлийг хуварилан эзэмшүүлснээр “Хар бут”-ны төгөлийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын эхлэл болжээ. Нөхөрлөлүүд хуваарьтай талбайдаа харуул хамгаалалт тавих, арчилж тордох үүрэгтэйгээс гадна чацарганыг нь түүж борлуулан ашиг шимийг нь хүртэх боломж бүрджээ. “Ээлтэй нутаг” хоршоо тус төгөлөөс жилд 3-6 тонн чацарганы жимс бэлтгэдэг. Завхан голын дагуу нөхөн сэргээлт хийн хашиж хамгаалан тарьж ургуулсан чацарганы төгөл 2009 оноос жимс өгч 600 гаруй модноос 1 тн жимс хураан авсан байна.

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар

Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187

Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn